



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монголын төмөр зам Төрийн өмчит хувьцаат компанийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/51/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот</p> <p>2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас:51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Энхжаргал Утас: 51-261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:Уваа уул Аудит ХХК-ийн захирал Ч.Мөнхтуяа Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	11
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	13
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	15
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин	15
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	16
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	17
3.7 Төсөл хөтөлбөрийн үе шат.	17
3.8 Үнэт цаас, бонд.....	18
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5.1 Завсрын аудитын талаар	22
Зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй албан томилолттой холбоотой асуудалд албан шаардлага хүргүүлэв.	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5.1 Албан шаардлага	24
5.2 Зөвлөмж.....	25
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХАБЭА	Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуй



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/730
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 36,117.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Харилцагч 60 байгууллагын 26,302.6 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр, 115 байгууллагын 4,237.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тус тус тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Хоёр харилцагчийн авлагын дүн тооцоо нийлсэн актын дүнгээс 3,678.9 сая төгрөгөөр дутуу буюу зөрүүтэй баталгаажуулсан;
- Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж 581.6 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн;

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4 13.6, 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд

санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "үнэн зөв байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй.

Асуудлыг онцолсон хэсэг

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Чайна энерги коксжих нүүрс (Тяньжин)" ХХК-тай 2025 оны 05 дугаар сарын 14-нд "Нүүрс тээвэрлэлтийн урт хугацааны гэрээ"-г байгуулж Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, Гашуунсухайт-Ганцмод боомт чиглэлд авто тээврийн үйл ажиллагааг эхлүүлснээр орлогын гүйцэтгэл 298,660.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 16,533.7 сая төгрөг буюу 6.0 хувиар давж тайлант оны цэвэр ашиг 38,172.7 сая төгрөг болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын 2025 оны "Эрдэнэс Тавантолгой" ХК, Монголын төмөр зам ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 65 дугаар тогтоолоор "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 34 хувь буюу 693,763.1 сая төгрөгийн хувьцааг "Эрдэнэс Тавантолгой" ХК-д шилжүүлсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 522 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд байрлах Төмөртэйн өртөөг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-д шилжүүлсэнтэй холбоотойгоор Монголын төмөр зам ТӨХК-ийн хөрөнгөд бүртгэлтэй 6,617.6 сая төгрөгийн хөрөнгийг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-д шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Монголын төмөр зам ТӨХК нь тайлант онд ачаа тээврийн төлөвлөгөөг 7511 сая тонн байхаар баталсан бөгөөд гүйцэтгэлээр 8575 тонн ачаа тээвэрлэж төлөвлөгөөг 14.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ



“Монголын төмөр зам” Төрийн өмчит хувьцаат компанийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	59,535,646,696.37	4,687,813,581.27
1.1.2	Дансны авлага	25,450,546,085.01	34,643,696,462.77
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	15,361,895,432.76	81,078,167,163.41
1.1.4	Бусад авлага	68,644,836,207.35	93,099,747,608.16
1.1.6	Бараа материал	14,344,060,064.82	23,972,659,075.12
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	37,638,075,752.24	46,630,449,680.36
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	2,611,870,635.56	2,611,870,635.56
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	223,586,930,874.11	286,724,404,206.65
1.2.1	Үндсэн хөрөнгө	232,371,994,081.84	1,440,682,386,325.32
1.2.2	Биет бус хөрөнгө	13,442,376,432.89	26,797,675,094.08
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	693,765,710,701.48	1,510,000.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	6,043,448,439.76	6,043,448,439.76
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	11,706,564.64	-
1.2.9	Дуусаагүй барилга	1,385,599,831,047.05	596,649,349,666.24
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,331,235,067,267.66	2,070,174,369,525.40
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,554,821,998,141.77	2,356,898,773,732.05
2.1.1.1	Дансны өглөг	5,599,641,586.52	30,391,325,866.05
2.1.1.2	Цалингийн өглөг	-	46,576,480.51
2.1.1.3	Татварын өр	21,853,826,351.80	1,575,000,386.08
2.1.1.4	НДШ - ийн өглөг	27,679,561.34	1,763,870,557.05
2.1.1.6	Хүүний өглөг	8,863,385,691.15	25,256,048,667.19
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	3,622,153,863.24	4,164,769,341.92
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	15,424,566,803.88	354,309,461,889.48
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	55,391,253,857.93	417,507,053,188.28
2.1.2.1	Урт хугацаат зээл	334,682,989,366.50	335,306,224,268.52
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	3,044,910,142.72	3,044,910,142.72
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,475,504,630,885.05	870,268,060,865.59
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,813,232,530,394.27	1,208,619,195,276.83
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,868,623,784,252.20	1,626,126,248,465.11
2.3.1	Эздийн өмч	20,727,658,514.60	20,727,658,514.60
2.3.1.1	төрийн	20,727,658,514.60	20,727,658,514.60
2.3.1.2	хувийн	-	-
2.3.1.3	хувьцаат	-	-
2.3.2	Халаасны хувьцаа	-	-
2.3.3	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.4	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	766,546,968.88	766,546,968.88
2.3.6	Эздийн өмчийн бусад хэсэг	768,206,030,794.14	781,509,456,794.14
2.3.7	Хуримтлагдсан ашиг	(103,502,022,388.05)	(72,231,137,010.68)
2.3.9	Эздийн өмчийн дүн	686,198,213,889.57	730,772,525,266.94
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,554,821,998,141.77	2,356,898,773,732.05

“Монголын төмөр зам” Төрийн өмчит хувьцаат компанийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	122,511,279,362.08	291,695,192,794.72
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	79,640,696,874.04	204,400,303,641.51
3	Нийт ашиг (алдагдал)	42,870,582,488.04	87,294,889,153.21
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	4,646,131,062.82	3,623,208,487.89
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	7,824,590,486.89	3,342,532,970.17
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	8,987,079,525.63	17,918,062,165.99
11	Санхүүгийн зардал	4,510,164,909.87	15,704,522,053.20
12	Бусад зардал	5,700,241,204.92	2,087,669.27
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(958,180,097.97)	(14,756,855,436.50)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	127,322,569.85	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	35,312,960,869.21	45,879,103,286.31
19	Орлогын татварын зардал	5,083,431,925.75	7,706,401,593.08
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	30,229,528,943.46	38,172,701,693.23
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	30,229,528,943.46	38,172,701,693.23
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	30,229,528,943.46	38,172,701,693.23
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

“Монголын төмөр зам” Төрийн өмчит хувьцаат компанийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	768,206,030,794.14	(133,902,313,305.64)	655,170,727,738.65
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	815,979,024.13	815,979,024.13
Залруулсан үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	768,206,030,794.14	(133,086,334,281.51)	655,986,706,762.78
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	30,229,528,943.46	30,229,528,943.46
Зарласан ногдол ашиг	-	-	-	(645,217,050.00)	(645,217,050.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	627,195,233.33	-	-	627,195,233.33
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	766,546,968.88	768,206,030,794.14	(103,502,022,388.05)	686,198,213,889.57
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(3,878,863,415.86)	(3,878,863,415.86)
Залруулсан үлдэгдэл	20,727,658,514.60	766,546,968.88	768,206,030,794.14	(107,380,885,803.91)	682,319,350,473.71
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	38,172,701,693.23	38,172,701,693.23
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	13,303,426,000.00	-	13,303,426,000.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	(3,022,952,900.00)	(3,022,952,900.00)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	766,546,968.88	781,509,456,794.14	(72,231,137,010.68)	730,772,525,266.94

“Монголын төмөр зам” Төрийн өмчит хувьцаат компанийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн	121,150,928,153.53	289,001,127,694.98
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	120,646,235,776.19	288,489,888,273.97
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	38,632,238.00	147,941,472.92
1.1.4	Буцаан авсан албан татвар	8,422,144.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	457,637,995.34	363,297,948.09
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	86,749,637,203.82	217,883,322,412.41
1.2.1	Ажиллагчдад төлсөн	20,482,629,941.91	40,275,826,399.44
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,964,831,893.80	9,265,458,440.68
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	13,347,549,632.00	6,081,358,552.08
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	9,091,877,712.67	7,060,996,339.79
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	14,470,177,837.76	76,749,335,090.13
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	499,999,298.37	5,959,685,327.97
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	18,091,431,874.07	31,879,475,551.11
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	56,083,094.79	1,414,427,754.14
1.2.9	Бусад мөнгөн зарлага	4,745,055,918.45	39,196,758,957.07
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	34,401,290,949.71	71,117,805,282.57
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн	3,809,406,140.63	4,393,995,489.70
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	3,809,406,140.63	4,393,995,489.70
2.2	Мөнгөн зарлагын дүн	60,908,470,049.35	315,112,117,803.12
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	56,290,872,689.35	313,022,126,153.62
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,500,000.00	18,122,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	2,071,869,649.50
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,612,097,360.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(57,099,063,908.72)	(310,718,122,313.42)
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн	41,558,349,032.00	197,866,045,258.33
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	41,558,349,032.00	80,870,322,758.33
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	116,995,722,500.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	645,217,050.00	12,644,105,330.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	12,644,105,330.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	645,217,050.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	40,913,131,982.00	185,221,939,928.33
4	Валютын ханшийн зөрүү	10,650.26	(469,456,012.58)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	18,215,369,673.25	(54,847,833,115.10)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	41,320,277,023.12	59,535,646,696.37
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	59,535,646,696.37	4,687,813,581.27

“Монголын төмөр зам” Төрийн өмчит хувьцаат компанийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 Гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйц	Хувь
	1	2	3	4	5	6	7	8	9
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:									
1	а. Хөдлөх бүрэлдэхүүн ба бусад түрээс	мян.төг	4,774,312	9,506,683	10,145,657	5,371,345	212.5	638,974	106.7
	б. Төмөртэй тээвэр	мян.төг	3,784,984	5,271,815	5,050,347	1,265,363	133.4	(221,468)	95.8
	в. Зам анги, бусад	мян.төг	2,907,400	15,287	229,062	(2,678,338)	7.9	213,775	1498.4
	г. Цогтцэций тээвэр	мян.төг	107,254,262	47,870,077	34,302,899	(72,951,363)	32.0	(13,567,178)	71.7
	д.Тавантолгой тээвэр	мян.төг		137,328,531	167,938,412	167,938,412		30,609,881	122.3
	е. ШАЦ, Замын-Үүд	мян.төг	3,790,322	5,333,673	5,333,698	1,543,376	140.7	25	100.0
	ё. Бусад орлого	мян.төг	12,470,722	76,801,103	75,660,860	63,190,138	606.7	(1,140,244)	98.5
2	Нийт орлого	мян.төг	134,982,002	282,127,169	298,660,934	163,678,932	221.3	16,533,765	105.9
3	Нийт зардал	мян.төг	98,838,182	240,642,547	238,024,976	139,186,794	240.8	(2,617,571)	98.9
3	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	8,987,080	13,382,621	17,918,062	8,930,982	199.4	4,535,441	133.9
4	Ханшийн зөрүүний ашиг/алдагдал	мян.төг	(958,180)	(18,482,137)	(14,756,855)	(13,798,675)	1,540.1	3,725,282	79.8
	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	мян.төг	127,323	-	-	(127,323)	-	-	-
	Татварын өмнөх ашиг/алдагдал	мян.төг	35,312,961	23,002,485	45,879,103	10,566,142	129.9	22,876,618	199.5
	Орлогын албан татвар	мян.төг	5,083,432	5,642,543	7,706,402	2,622,970	151.6	2,063,859	136.6
5	Цэвэр ашиг/ алдагдал	мян.төг	30,229,529	17,359,942	38,172,702	7,943,173	126.3	20,812,760	219.9
6	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	23,754,142	47,024,100	41,135,306	17,381,164	173.2	(5,888,794)	87.5
	а. Орлогын албан татвар	мян.төг	5,083,432	5,642,543	7,706,402	2,622,970	151.6	2,063,859	136.6
	б. НӨАТ	мян.төг	6,136,799	17,024,929	16,491,455	10,354,656	268.7	(533,474)	96.9
	в. НДШ	мян.төг	3,296,142	12,152,722	10,679,309	7,383,167	324.0	(1,473,413)	87.9
	г. Хүн амын орлогын албан татвар	мян.төг	2,300,040	4,514,208	2,946,770	646,730	128.1	(1,567,438)	65.3
	д. Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	2,663,975	3,681,838	62,425	(2,601,550)	2.3	(3,619,413)	1.7
	е. Гаалийн татвар	мян.төг	3,599,611	2,731,008	2,731,193	(868,418)	75.9	185	100.0
	ё. Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	4,841	18,340	3,886	(955)	80.3	(14,454)	21.2

**“Монголын төмөр зам” Төрийн өмчит хувьцаат компанийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

	ж. Бусад татвар	мян.төг	669,302	1,258,512	513,866	(155,436)	76.8	(744,646)	40.8
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	645,217	3,022,953	3,022,953	2,377,736	468.5	-	100.0
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	599	1,280	1,280	681	213.7	-	100.0
9	Нийт цалингийн сан	мян.төг	27,975,576	56,621,644	56,985,238	29,009,662	203.7	363,594	100.6
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	3,892	4,537	4,998	1,106	128.4	461	110.2
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.73	0.85	0.80	0.06	108.8	(0.06)	93.4
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	23,966,550	47,705,430	39,720,415	15,753,865	165.7	(7,985,015)	83.3
13	ХО-Багахангай-Хөшигийн хөндий төсөл	мян.төг		850,451,071	331,645,566	331,645,566		(518,805,505)	39.0
14	Нийт авлага	мян.төг	109,457,279	81,839,877	60,570,518	(48,886,761)	55.3	(21,269,359)	74.0
15	Нийт өглөг	мян.төг	1,868,623,784	2,005,376,926	1,626,126,248	(242,497,536)	87.0	(379,250,678)	81.1
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	55,391,254	33,537,428	69,517,517	14,126,263	125.5	35,980,089	207.3
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	1,813,232,530	1,174,439,498	1,187,348,769	(625,883,761)	65.5	12,909,271	101.1
	Урт хугацаат өр төлбөр /төсөл/	мян.төг		797,400,000	369,259,962	369,259,962		(428,140,038)	46.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Монголын төмөр зам ТӨХК нь Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 82 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 03 дугаар сарын 20-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор байгуулагдсан бөгөөд төмөр замын бүтээн байгуулалт, үндэсний сүлжээг хөгжүүлэх Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй, төмөр замын дэд бүтэц барих, эзэмших, ашиглах эрхтэй төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэгч компани юм.

Монголын төмөр зам ТӨХК нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Олон улсын сүлжээнд нэгдсэн, үндэсний төмөр замын сүлжээг хөгжүүлэх, төмөр замын салбарын хөгжлийг тодорхойлогч үндэсний компани байх ” гэж тодорхойлсон байна.

Төмөр замын тухай хууль болон компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

- Төмөр замын суурь бүтэц барих, эзэмших, ашиглах;
- Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг угсрах, засварлах, түрээслэх, суурь бүтцийг засварлах, арчлах;
- Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх;
- Төмөр замын төсөл, төсөв, ТЭЗҮ боловсруулах;
- Компани нь дүрэмд заасан зорилтоо хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанаас гадна хуулиар хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагааг эрхэлж болох бөгөөд тухайн шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана;
- Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний дараа үйл ажиллагааг эхлүүлнэ;
- Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд компани нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

Тайлант онд 6 зорилт дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Төмөр замын тээврийн хэмжээг нэмэгдүүлэх;
2. Төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх;
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах;
4. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах;
5. Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, компанийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулж гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;
6. Дотоод аудит, тээврийн хяналт шалгалт хийж, зөвлөмж, шаардлага өгөх замаар илэрсэн зөрчлийг арилгуулж, ажлыг сайжруулна.

Монголын төмөр зам ТӨХК-ийн хараат, охин компаниуд:

1. “Монголиан порт групп” ХХК-ийн 51 хувь,
2. “Шивээ хүрэн төмөр зам” ХХК-ийн 51 хувь,
3. “Арц суурь-Нарийн сухайт-Шивээ хүрэн төмөр зам” ХХК-ийн 5 хувь
4. “Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам ХХК”-ийн 5 хувь,
5. “Шинэ төмөр зам” ХХК-ийн 100 хувь

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.12-т заасны дагуу эзэмшиж буй хувьцааны эрхийн хүрээнд ТУЗ-д хувьцаа эзэмшигчдийн төлөөллөөр хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монголын төмөр зам ТӨХК нь 100 хувь төрийн өмчит компани бөгөөд Төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага болох Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Монголын төмөр зам ТӨХК нь үйл ажиллагаандаа Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Төмөр замын тээврийн үндсэн дүрэм, Төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албаны дүрэм, “Төмөр замын ажилтны сахилгын дүрэм” Засгийн газрын тогтоол болон зам тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан 30 орчим нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төмөр замын тээврийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Үндэсний баялгийн сангийн тухай хууль;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай;
- Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Төмөр замын салбар зам барихтай холбоотой зарим арга хэмжээний тухай” 21 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2025 оны “Эрдэнэс Тавантолгой ХК, Монголын төмөр зам ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 65 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны “Багахангай Хөшгийн хөндий чиглэлийн салбар салбар төмөр замын төслийн талаар авах зарим арга тухай” 86 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны “Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 103 дугаар тогтоол;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 албан даалгавар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай”;
- Үйл ажиллагааны дотоод журам;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Монголын төмөр зам ТӨХК-ийн Хяналтын алба нь 2025 оны төлөвлөгөөнд дотоод аудитын хүрээнд 1 зорилтын 7 заалт бүхий дотоод аудитыг хийхээр төлөвлөснөөс санхүүгийн үйл ажиллагаанд цалин хөлс, албан томилолтын зардалтай холбоотой 2 аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны А/224 дугаар тушаалаар боловсруулсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг баталж, үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг холбогдох стандартад нийцсэн боловч Төмөр замын салбартай холбоотой вагон, зүтгүүрийн өдөр тутам гарч буй хөрөнгийн хөдөлгөөнийг баримтжуулах, бүртгэх, хүлээн зөвшөөрөх, хөрөнгийн тооллого хийж баталгаажуулах, хяналт тавих болон урт хугацаат хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, вексель эзэмших эрхийн талаар өөрийн онцлогт тохирсон асуудлуудыг тусгаагүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн сайжруулалт хийх худалдан авах ажиллагааг 2025 оны 12 дугаар сард зохион байгуулж “Тэгш сонголт эстимэйт үнэлгээ” ХХК шалгарсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монголын төмөр зам ТӨХК нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 197,923.2 сая төгрөгөөр буюу 7.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	59,535,646.7	4,687,813.6	(54,847,833.1)
Авлага	109,457,277.7	208,821,611.2	99,364,333.5
Урьдчилж төлсөн зардал	37,638,075.8	46,630,449.7	8,992,373.9
Бараа материал	14,344,060.1	23,972,659.1	9,628,599.0
Бусад эргэлтийн хөрөнгө	2,611,870.6	2,611,870.6	-
Үндсэн хөрөнгө	232,371,994.1	1,440,682,386.3	1,208,310,392.2
Биет бус хөрөнгө	13,442,376.4	26,797,675.1	13,355,298.7
Урт хугацаат хөрөнгө оруулалт	693,765,710.7	1,510.0	(693,764,200.7)
Хойшлогдсон татварын хөрөнгө	6,043,448.4	6,043,448.4	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	11,706.6	-	(11,706.6)
Дуусаагүй барилга	1,385,599,831.0	596,649,349.7	(788,950,481.4)
Нийт хөрөнгө	2,554,821,998.1	2,356,898,773.7	(197,923,224.4)
Богино хугацаат өр төлбөр	55,391,253.9	417,507,053.2	362,115,799.3
Урт хугацаат өр төлбөр	1,813,232,530.4	1,208,619,195.3	(604,613,335.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	686,198,213.9	730,772,525.3	44,574,311.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,554,821,998.1	2,356,898,773.7	(197,923,224.4)

Өмнөх оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, урт хугацаат хөрөнгө оруулалт, дуусаагүй барилга, өр төлбөр, эздийн өмчийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,687.8 сая төгрөг болж 54,847.8 сая төгрөгөөр буурсан нь Засгийн газрын 2025 оны 86 дугаар тогтоолын дагуу Багахангай-Хөшигийн хөндий төслийг санхүүжүүлж, Сангийн яамтай байгуулсан “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх”, “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн нийлүүлэх”, “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх” төслүүдийн дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлт хийгдсэнтэй холбоотой;

- Авлага дансны үлдэгдэл 208,821.6 сая төгрөг болж 99,364.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны дансны авлага 4,878.4 сая төгрөг, ажиллагсадтай холбоотой авлага 164.3 сая төгрөг, Багахангай-Хөшигийн хөндийн төслийн хойшлогдсон НӨАТ-ын авлага 22,429.5 сая төгрөг, шүүхийн шатны авлага 2,626.2 сая төгрөг, хойшлогдсон НӨАТ-ын авлага, татварын алданги 50,953.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс голлон шалтгаалсан;
- Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 46,630.4 сая төгрөг болж 8,992.3 сая төгрөгөөр өссөн нь Багахангай-Хөшигийн хөндий төслийн гүйцэтгэлийн шивэгдээгүй НӨАТ-ын төлбөр 14,677.3 сая төгрөг, Шүүхийн шийдвэрийн дагуу Тавантолгой-Зүүнбаян төслийн гүйцэтгэлийн төлбөр 2,771.0 сая төгрөгийг урьдчилж төлсөн зэргээс шалтгаалсан;
- Бараа материалын дансны үлдэгдэл 23,972.7 сая төгрөг болж 9,628.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан 82,799.2 сая төгрөгийн бараа материал Тавантолгой-Зүүнбаян төслийн үлдэгдэл нөөц 3,181.4 сая төгрөгийн бараа материалыг бүртгэж авснаас шалтгаалжээ;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,440,682.4 сая төгрөг болж 1,208,3 сая төгрөгөөр өссөн бөгөөд тайлант хугацаанд дараах хөдөлгөөн өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:
 - Барилга байгууламжийн дансанд ТӨБЗГ-ын 2025 оны 797 дугаар тогтоолоор Зүүнбаян-Цогтцэций төмөр замын төслийн хөрөнгийг дуусаагүй барилга байгууламжийн данснаас шилжүүлэн бүртгэсэн 1,200,522.6 сая төгрөг, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдан авсан Зүүнбаян-Цогтцэций төмөр зам дагуу барьж байгуулсан 11,124.2 сая төгрөгийн 219 км урттай төмөр замын хориг хашаа зэрэг нийт 1,211,646.8 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн;
 - Тээврийн хэрэгслийн дансанд 49 хоппер вагон, 4 зүтгүүрийг засвар үйлчилгээнд оруулж 22,417.3 сая төгрөгөөр капиталжуулсан, 935.3 сая төгрөгийн 10 автомашин худалдан авч, ТӨБЗГ-ын 2025 оны 621 дүгээр тогтоолоор 169.0 сая төгрөгийн 1 автомашиныг ЗТЯ-аас шилжүүлэн авч нийт 23,521.6 сая төгрөгөөр нэмэгдсэн;
 - Машин, тоног төхөөрөмж дансанд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу төв оффист худалдан авсан сүлжээний тоног төхөөрөмж 139.7 сая төгрөгөөр нэмэгдсэн;
 - Компьютер, дагалдах хэрэгслийн дансанд нь иж бүрэн суурин компьютер 54 ширхэг, принтер 21 ширхэг, бусад дагалдах хэрэгслийн худалдан авч нийт 729.7 сая төгрөгөөр нэмэгдсэн;
 - Тавилга эд хогшил дансанд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу төв оффис-д худалдан авсан 176.7 сая төгрөгөөр нэмэгдсэн;
 - Программ хангамжийн дансанд хүний нөөц, төмөр замын тээврийн программ хангамж худалдан авч 85.2 сая төгрөгөөр нэмэгдсэнээс тус тус шалтгаалсан байна;

Мөн ТӨБЗГ-ын 2025 оны 522 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд байрлах Төмөртэйн өртөөг “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-д шилжүүлсэнтэй холбоотойгоор ТӨБЗГ-ын 2025 оны 12 сарын 17 өдрийн 751 дугаар тогтоолоор “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-д 6,617.6 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн данснаас хасаж тайлант хугацаанд 15,596.9 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

- Биет бус хөрөнгийн данс 26,797.6 сая төгрөг болж 13,355.2 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2025 оны А-1/1764 дугаар зөвшөөрлөөр Зүүнбаян-Цогтцэций төмөр замын эрчим хүч дамжуулах шугам, сүлжээний 8 ширхэг 239.5 га газрыг 13,303.4 сая төгрөгөөр үнэлж бүртгэсэнтэй холбоотой.
- Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс 1.5 сая төгрөг болж 693,765.7 мянган төгрөгөөр буурсан нь Засгийн газрын 2025 оны 65 дугаар тогтоолын 1, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2025 оны 01/578 тоот удирдамж, Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын

2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/37 дугаар тушаал, Тавантолгой төмөр зам ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 01 Монголын төмөр зам ТӨХК-ийн эзэмшиж байгаа Тавантолгой төмөр зам ХХК-ийн 34 хувийн хувьцааг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д шилжүүлэх тухай” тогтоолоор нэг бүр нь 2500 төгрөгийн үнэ бүхий 277,505,246 ширхэг нийт 693,763.1 сая төгрөгийн 34 хувийн хувьцааг Монголын төмөр зам ТӨХК-ийн гаргасан 750,000.0 сая төгрөгийн бондоос суутган тооцож “Эрдэнэс Тавантолгой” ХК шилжүүлсэнтэй холбоотой;

- Хөрөнгө оруулалтын зориулалтай үл хөдлөх хөрөнгө данс 11.7 сая төгрөгөөр буурсан нь Таван толгой-Зүүн баян чиглэлийн төслийн хөрөнгийн үлдэгдэл бөгөөд Гүйцэтгэх захирлын 2025 оны А/297 тоот тушаал, ТУЗ-ын 2025 оны 35 дугаар тогтоолыг үндэслэн дутагдсан хөрөнгийг залруулга бичилт хийсэнтэй холбоотой;
- Дуусаагүй барилга дансны үлдэгдэл 596,649.3 сая төгрөг болж 788,950.5 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2025 оны 797 дугаар тогтоолоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг барилга байгууламжийн дансанд шилжүүлэн бүртгэж, Багахангай-Хөшигийн хөндий төслийн 418,980.0 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 417,507.0 сая төгрөг болж 362,115.8 сая төгрөгөөр өссөн нь Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр замын төслийн хүрээнд санхүүжүүлсэн Тавантолгой төмөр зам ХХК-ийн 77,370.4 сая төгрөг, Бондын 120,500.0 сая төгрөг, Багахангай-Хөшигийн төслийн хянан баталгаажуулсан гэрээт ажлын өглөг 141,904.2 сая төгрөг, Сангийн яамтай байгуулсан дамжуулан зээлдүүлэх зээлийн хүүгийн өр төлбөр 10,378.3 сая төгрөг, Бондын хүүгийн өр төлбөр 6,014.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ.
- Урт хугацаат өр төлбөр данс 1,208,619.2 сая төгрөг болж 604,613.3 сая төгрөгөөр буурсан нь Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны өөрчлөлттэй холбоотой байна.
- Эздийн өмчийн дансны үлдэгдэл 730,772.5 сая төгрөг болж 44,574.3 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2025 оны А-1/1764 дугаар зөвшөөрлөөр 13,303.4 сая төгрөгийн газрын үнэлгээ, 38,172.7 сая төгрөгийн цэвэр ашиг тус тус бүртгэсэнтэй холбоотой байна.

Судалгааны үр дүн: Тус компанийн биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2016-2025 онд худалдан авсан 1.9 сая төгрөгөөр өртөгтэй санхүүгийн Даймонд программ, 18.2 сая төгрөгийн өртөгтэй санхүүгийн Юникус программ, 56.0 сая төгрөгийн өртөгтэй санхүүгийн Смарт программ, 11.5 сая төгрөгийн өртөгтэй хүний нөөцийн программ, 19.8 сая төгрөгийн өртөгтэй пүүний программ хангамжууд тус тус бүртгэлтэй байна. Тайлант онд санхүүгийн программ хангамжийг хөгжүүлэхтэй холбоотой 29.6 сая төгрөгийн зардал гарсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТӨБЗГ-ын 2024 оны 718 дугаар тогтоолоор нийт орлогыг 194,747.1 сая төгрөг, нийт зарлагыг 176,432.6 сая төгрөг, цэвэр ашгийг 16,483.1 сая төгрөг, төрийн өмчийн ногдол ашгийг 456.5 сая төгрөг, хөрөнгө оруулалтыг 41,479.3 сая төгрөг, нийт авлагыг 81,839.9 сая төгрөг, богино хугацаат өр төлбөрийг 17,140.7 сая төгрөг, урт хугацаат өр төлбөрийг 1,868,202.6 сая төгрөг, нийт ажилчдын тоог 599 байхаар баталсан байна.

Засгийн газрын 2025 оны 103 дугаар "Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд компанийн бүтэц орон тоо, ачаа тээврийн эргэлт нэмэгдэж түүнтэй холбоотойгоор орлого, зарлагын өөрчлөлт орох болсон тул ТӨБЗГ-ын 2025 оны 247 дугаар тогтоолоор Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны эдийн засгийн

үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол оруулж нийт орлогыг 247,173.7 сая төгрөг, нийт зардлыг 234,629.4 сая төгрөг, цэвэр ашгийг 11,289.9 сая төгрөг, төрийн өмчийн ногдол ашгийг 604.6 сая төгрөг, хөрөнгө оруулалтыг 47,206.1 сая төгрөг, нийт авлагыг 81,839.9 сая төгрөг, богино хугацаат өр төлбөрийг 33,537.4 сая төгрөг, урт хугацаат өр төлбөрийг 1,174,439.5 сая төгрөг, нийт ажилчдын тоог 950 байхаар тодотгож баталсан байна.

Монголын төмөр зам ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийх тухай” 32 дугаар тогтоолоор нийт орлогыг 282,127.2 сая төгрөг, нийт зардлыг 240,642.5 сая төгрөг, цэвэр ашгийг 20,702.2 сая төгрөг, төрийн өмчийн ногдол ашгийг 3,022.9 сая төгрөг, хөрөнгө оруулалтыг 47,705.4 сая төгрөг, Багахангай-Хөшигийн хөндий төслийн 850,451.1 сая төгрөг, авлагыг 81,839.9 сая төгрөг, богино хугацаат өр төлбөрийг 33,537.4 сая, урт хугацаат өр төлбөрийг 1,174,439.5 сая төгрөг, Урт хугацаат өр төлбөр /Багахангай-Хөшигийн хөндий төсөл/ 797,400.0 сая төгрөг, нийт ажилчдын тоог 1280 байхаар тодотгож баталсан байна.

Тайлант онд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2 удаагийн тодотгол хийгдэж нийт орлого 87,380.1 сая төгрөг буюу 44.9 хувь, нийт зардал 64,209.9 сая төгрөг буюу 36.4 хувь, цэвэр ашиг 4,219.1 сая төгрөг буюу 25.6 хувь төрийн өмчийн ногдол ашиг 2,566.4 сая төгрөг буюу 562.0 хувь, хөрөнгө оруулалт 6,226.1 сая төгрөг буюу 15.0 хувь, нийт ажилчдын тоо 681 буюу 113.7 хувь, богино хугацаат өр төлбөр 16,396.7 сая төгрөг буюу 95.7%, урт хугацаат өр төлбөр 103,639.9 сая төгрөг буюу 5.5 хувиар тус тус нэмэгдсэн бол Багахангай-Хөшигийн хөндий төслийн 850,451.1 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийг шинээр нэмж баталсан байна.

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 298,660.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж 238,024.9 сая төгрөгийн зардал гарган, валютын ханшийн алдагдал 14,756.9 сая төгрөг болж 45,879.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 298,660.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 16,533.7 сая төгрөг буюу 6.0 хувиар давсан нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “Чайна энерги коксжих нүүрс (Тяньжин) ”ХХК-тай 2025 оны 05 дугаар сарын 14-нд “Нүүрс тээвэрлэлтийн урт хугацааны гэрээ”-г байгуулж нүүрс тээвэрлэлт нэмэгдснээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 238,024.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,617.6 сая төгрөг буюу 1.0 хувийн дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2025 оны 02 сарын 12-ны өдрийн “Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 86 дугаар тогтоолын 1 дүгээр заалтын дагуу төслийн арга хэмжээнд 117,551.4 сая төгрөгийн санхүүжилтийг 2025 оны үйл ажиллагааны орлогоос санхүүжих болсонтой холбоотойгоор дараах зардлууд гарсан байна. Үүнд:

- Цалингийн зардал 164.7 сая, шатах тослох материалын зардал 4,242.4 сая, ХАБЭА-н зардал 3,718.4 сая, техник мэргэжлийн үйлчилгээний зардал 4,602.2 сая төгрөг, засварын зардал 2,064.5 сая төгрөг, багаж хэрэгсэл, сэлбэгийн зардал 12,447.7 сая төгрөг, тээвэр, шуудан, ашиглалтын зардлыг 1,561.9 сая төгрөг, богиноны автотээврийн зардал 17,959.1 сая төгрөг, зам арчилгааны зардал 1,665.2 сая төгрөг, хоолны зардал 1,247.0 сая төгрөг, маркетинг, сургалт, даатгал, албан татвар, харуул хамгаалалт, тэтгэмжийн зардлыг 1,466.6 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулж;
- ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 797 тоот тогтоолын дагуу 416 км замыг хөрөнгөд бүртгэж 2023, 2024 оны өмнөх үеийн элэгдлийн зардлыг нөхөн бүртгэж төлөвлөснөөс 33.5 хувиар илүү буюу 32,299.1 сая төгрөгөөр элэгдлийн зардал, хүүгийн зардал 11,266.8 сая төгрөг, бусад зардал 5,135.5 сая төгрөгийн тус тус илүү зарцуулалтаас голлон шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 205 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээр санхүүжих 39,720.4 сая төгрөгийн худалдан авалтыг санхүүжүүлсэн бол Багахангай-Хөшигийн хөндий төслийн 331,645.6 сая төгрөгийн зардлыг Засгийн газрын 2025 оны 21, 86 дугаар тогтоолын дагуу санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 38,172.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 20,812.8 сая төгрөгөөр илүү байгаа нь тайлант оны орлого 16,533.8 сая төгрөгөөр давж, зардал 2,617.6 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Тайлант онд ТӨБЗГ-т ногдол ашиг 3,023.0 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлжээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Монголын төмөр зам ТӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.11 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 7.3 дэх заалт, компанийн гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/22 дугаар “Хоол, унааны нэмэгдэл олгох тухай” тушаалыг тус тус үндэслэн 1 хүнд ногдох унаа, хоолны хөнгөлөлтийг өдрийн 30.9 мянган төгрөгөөр тогтоож тайлант хугацаанд 1,249.5 сая төгрөгийн хөнгөлөлт олгосон байна.
- Тайлант онд нийт 41 удаагийн салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг олгох, ХАБЭА мэдлэг олгох сургалт, семинар, гадаад харилцаа, хамтын ажиллагааны хурал зөвлөгөөн зэргийг зохион байгуулж 134.6 сая төгрөгийн зардал гаргасан.
- Томилолтын зардал 840.3 сая төгрөг батлагдсанаас гадаад албан томилолтын 24 удаагийн арга хэмжээнд 194.7 сая төгрөгийн зардал гарсан байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд Монголын төмөр зам ТӨХК 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 718 дугаар тогтоолоор батлуулж, 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 196, мөн оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 247 дугаар тогтоолоор тодотгол оруулж нийт 213 бараа, ажил, үйлчилгээний 208,019.7 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталсан байна. Үүнд:

Хөрөнгө оруулалтын худалдан авалт: Хөрөнгө оруулалтын 113,911.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 49 төсөл арга хэмжээнээс 108,918.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан байна.

Байгууллагын үйл ажиллагааны худалдан авалт: Төлөвлөгөөгөөр 92,175.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 43 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс 88,564.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 36 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалт, харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.

Шууд худалдан авалтын 1,933.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 121 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс 1,409.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 87 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулсан байна.

2025 оны 12 дугаар сард 3,202.4 сая төгрөгийн төсөв өртөгтэй 14 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар www.tender.gov.mn цахим системд байршуулсан бөгөөд 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үр дүн гараагүй байна.

3.7 Төсөл хөтөлбөрийн үе шат.

Засгийн газрын 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн “Төмөр замын салбар зам барихтай холбоотой зарим арга хэмжээний тухай” 21 дүгээр тогтоолд “Багахангай өртөөнөөс Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх Хөшигийн хөндий чиглэлийн салбар замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг боловсруулж, зохих журмын дагуу магадлал хийлгээсний үндсэн дээр барилгын ажлыг эхлүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг төмөр замын суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит компаниудын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр” мөн Засгийн газрын 2025 оны “Багахангай-Хөшигийн хөндий

чиглэлийн салбар төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 86 дугаар тогтоолд “Багахангай-Хөшигийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэхэд шаардлагатай хөрөнгийг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2024 оны цэвэр ашиг, 2025 оны үйл ажиллагааны орлогоос санхүүжилт”-ийг шийдвэрлүүлэхээр тус тус тогтоосон байна.

Багахангай-Хөшигийн хөндий чиглэлд шинээр баригдах салбар төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг “Монголын төмөр зам” ТӨХК хариуцан боловсруулж тус төмөр зам нь Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн сум, Улаанбаатар хотын Хан-Уул, Багахангай дүүргийн нутаг дэвсгэрээр дамжих 151.5 километр дэлгэмэл урттай, 3 дугаар зэрэглэлийн, 25 тн-ын голын даацтай, 12.2 сая метр куб ухмалын ажил, 8.3 сая метр куб далангийн ажил, 115 ширхэг ус өнгөрүүлэх хоолой, 5 байршилд нийтдээ 2.5 километр урт төмөр бетон гүүрэн байгууламжтай байхаар боловсруулагдсан байна.

Төслийг хоёр үе шаттай хэрэгжүүлэхээр баталсан. Нэгдүгээр үе шатанд Багахангай өртөөнөөс Хөшигийн хөндийн логистик төв хүртэл 87.2 км төмөр зам, Хоёр дахь үе шатанд Хөшигийн хөндий-Шувуун фабрик чиглэлийн 15.6 км төмөр зам, нийт хөрөнгө оруулалтыг 1,209,500.3 сая төгрөг байхаар ТЭЗҮ гарсан байна.

Төслийн нэгдүгээр үе шатны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТӨБЗГ-ын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 196 дугаар тогтоолоор 850,451.0 сая төгрөг байхаар баталсан байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газрын 2025 оны 21, 86 дугаар тогтоолын дагуу “Таван толгой төмөр зам” ХХК-аас 77,370.4 сая төгрөг, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2024 оны цэвэр ашиг, 2025 оны үйл ажиллагааны орлогоос 117,551.4 сая төгрөг, Засгийн газрын 132 дугаар тогтоолын дагуу гаргасан бондоос 120,500.0 сая төгрөгийн нийт 315,338.0 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр төслийн ажлын хүрээнд давхардсан тоогоор 93 аж ахуй нэгж байгууллагатай 622,824.9 сая төгрөгийн гэрээ байгуулж тайлант онд 74.1 хувь буюу 461,613.7 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан байна.

2025 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар санхүүгийн байдлын тайланд 141,755.9 сая төгрөгийн гүйцэтгэлийн өр төлбөр, 21,332.2 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр (чанарын баталгаа) 443,316.2 сая төгрөгийн дуусаагүй барилга дансанд бүртгэгдсэн байна.

Нэгдүгээр үе шатны ажлын гүйцэтгэлийг баталсан төсөв, гүйцэтгэл, хянан баталгаажуулсан ажлын гүйцэтгэлтэй харьцуулж дараах хүснэгтээр харуулав.

Д.Д	Батлагдсан төсөв /сая төгрөг/	Гүйцэтгэл /сая төгрөг/	Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн хувь	Гүйцэтгэлээс хянан баталгаа жуулсан ажил /сая төгрөг/	Гүйцэтгэл, хянан баталгаа жуулсан ажлын хувь	Батлагдсан төсөв, хянан баталгаа жуулсан ажлын хувь
1	850,451.0	622,824.9	73.2%	461,613.7	74.1%	54.3%

Төслийн нэгдүгээр үе шатны ажлын төмөр замын суурь бүтцийн газар шорооны ажлын баталсан төсвөөс гүйцэтгэл нь 73.2хувь, баталсан төсөв, 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр хянан баталгаажуулсан ажлын гүйцэтгэл 54.3 хувьтай байна.

3.8 Үнэт цаас, бонд

Монголын төмөр зам ТӨХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 11 дүгээр сарын 07-ний өдрийн 27 дугаар “Үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр замын 1 дүгээр үе шатны ажилд шаардлагатай 300,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу Биржийн бус зах зээл дээр хөтөлбөртэй бонд гаргах шийдвэр гарч нэг бүр нь 1.0 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 300,000 ширхэг, 12 сарын хугацаатай, 17 хувь хүртэл хүүтэй, хагас жил тутам хүү төлөх нөхцөлтэйгээр, Бондын эргэн төлөлтийн барьцаанд тээврийн орлогыг барьцаалахыг компанийн ТУЗ зөвшөөрсөн байна.

Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны бүртгэлийн хорооны 2025 оны Монголын төмөр зам ТӨХК-ийн өрийн хэрэгслийг бүртгэх тухай 25/154 дүгээр тогтоолоор 300,000.0 сая төгрөгийн үнэ бүхий өрийн хэрэгслийг биржийн бус зах зээлийн үнэт цаасыг бүртгэх “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д бүртгүүлэх, өрийн хэрэгслийн үнэт цаасны бүрдүүлбэр, анхдагч зах зээлд арилжаалах хуваарь эхлэх болон хаах өдрийг Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоонд тухай бүр мэдэгдэж байхыг “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК-ууд тус тус даалгасан байна.

“МТЗ Бонд” нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар арилжааны 6 банк 120,500.0 сая төгрөгийн бондыг худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Монголын төмөр зам ТӨХК түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулахаар байгууллагын цалин хөлсний бодлогыг боловсронгуй болгох, анхан шатны баримтын бүрдэл, баталгаажуулалтыг иж бүрэн хангах, өглөг, авлагын тооцоог акт үйлдэн баталгаажуулах, бараа материалын хөдөлгөөнийг үнэн зөв бүртгэх, ажилтнуудын ээлжийн амралтын хуваарийг баталж мөрдүүлэх, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу ил тод зохион байгуулах, үндсэн хөрөнгийн бүртгэл, үнэлгээг шинэчлэн сайжруулах, тээврийн хэрэгслийн ашиглалт, шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, замын хуудсыг бүрэн хөтөлж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2026 оны 02 дугаар сарын 15-аас 2026 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Уваа уул аудит ХХК-ийн аудитор Б.Буяндэлгэр, Б.Энхтуяа, А.Оюун аудиторын туслах Э.Номинчулуун нар гүйцэтгэж, захирал Ч.Мөнхтуяа анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Энхжаргал, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Монголын төмөр зам ТӨХК нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/445 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн Орлогын дэлгэрэнгүй тайланг, суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 135,109.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,351.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд тайлант онд байгууллагын бүтэц орон тоо, үйл ажиллагааны орлого 2.2 дахин өссөн тул АОУС-320-А13-д заасны дагуу шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2025 оны Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 298,660.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,986.6 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор байгууллага нь шатах тослох материалын зардлыг 4,242.4 сая төгрөг, засварын зардлыг 2,064.5 сая төгрөг, ашиглалтын зардлыг 1,296.9 сая төгрөг, багаж хэрэгсэл, сэлбэг материалын зардлыг 12,447.7 сая төгрөг, түрээсийн зардлыг 179.2 сая төгрөг, шуудан холбооны зардлыг 88.5 сая төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан боловч дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн хуулийг зөрчин байгууллагын хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулж 59.7 сая төгрөгийн зардал гарсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах” 4.2.2-т “хэмнэлтийн горим нь иргэд, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, тэдний дэмжлэгийг хүлээхүйц түвшинд тодорхойлогдсон байх”, 15 дугаар зүйлийн 15.1

"Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээний зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг хийлгэхээр хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулж 150.0 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4 "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгууллага хамт олныг сурталчлах зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 28 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд төрийн өмчит аж ахуй нэгжийн байршуулбал зохих 182 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 348 гүйлгээний 283,556.6 сая төгрөг, зарлагын 1305 гүйлгээний 170,633.0 сая төгрөгийн мэдээллийг тус тус хугацаанд нь бүрэн оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Засгийн газрын 2025 оны 103 дугаар "Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын дагуу Таван толгой төмөр зам ХХК-аас Монголын төмөр зам ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулахаар нийт 3,364,120.5 сая төгрөгийн суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, үндсэн хөрөнгийг хүлээн авахаас 3,035,903.8 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авч баримтжуулсан, 328,216.7 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн аваагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 8 "Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй", 31 дүгээр

зүйлийн 3 "Засгийн газар тогтоол, Ерөнхий сайдын захирамжийг тэдгээрийн заалтыг хариуцан гүйцэтгэх байгууллагад тараан хүргүүлж, биелэлтийг нь хянан шалгаж, зохион байгуулан үр дүнг хугацаанд нь тооцож байвал зохино", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.6."хуульд заасан бусад тохиолдолд", 20 дугаар зүйлийн 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Засгийн газрын 2025 оны 103 дугаар "Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1-дэх заалт "Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, төмөр замын тээврийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилгоор Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг Монголын төмөр зам ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах арга хэмжээ авахыгтус тус даалгасугай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2025 оны 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаагүй, Таван толгой төмөр зам ХХК-аас 328,216.7 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн аваагүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Байгууллагын бүтцийн нэгж, албан тушаал бүрээр үндсэн цалингийн сүлжээ батлаагүйгээс албан тушаалын цалин хөлсний хэмжээг хөдөлмөрийн гэрээгээр тогтоож байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1."Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ", Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 "энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн албан тушаалтны цалин хөлсний доод хэмжээг тогтоохдоо компанийн үндсэн цалингийн сүлжээ болон бусад холбогдох журмын хүрээнд тогтоож, хэвших зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны 2 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийж, илрүүлсэн алдаа, зөрчилд асуудлын бүртгэл хөтөлж 16,798.8 сая төгрөгийн алдаанд 7 залруулах, 220.8 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснийг үнэлж, хэрэгжээгүй зөвлөмжийг энэхүү аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,011.7 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 4.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1,914.5 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 93.2 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн байна. Хэрэгжилтийг шалгахад төлбөрийн актын биелэлт 100 хувь, албан шаардлагын биелэлт 100 хувь, зөвлөмжийн биелэлт 95.8 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	1	4,024.1	1	4,024.1	100.0
2	Албан шаардлага	4	1,914,534.1	4	1,914,534.1	100.0

3	Зөвлөмж	6	93,178.5	5	86,178.5	95.8
	Нийт дүн	11	2,011,736.7	10	2,011,736.7	97.7

Зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй албан томилолттой холбоотой асуудалд албан шаардлага хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монголын төмөр зам ТӨХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн анхаарал татсан дараах асуудлуудад дараагийн аудитаар горим сорил гүйцэтгэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

- Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр замын төслийн нэгдүгээр үе шатны ажил тайлант хугацааны эцэст 74.1 хувийн гүйцэтгэлтэй, санхүүжилтийг шийдвэрлэх 300,000.0 сая төгрөгийн бондын арилжааны гүйцэтгэл;
- Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр замын төслийн хоёрдугаар үе шатны Хөшигийн хөндий-Шувуун фабрик чиглэлийн 15.6 км төмөр замын ажлын хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэл;
- Авлагын дансанд бүртгэлтэй 3-5 жилийн насжилттай Шүүхийн шатанд байгаа 14 аж ахуйн нэгж байгууллагын 2,626.2 сая төгрөгийн авлага шийдвэрлэгдсэн эсэх;
- Багахангай-Хөшигийн хөндийн төслийн хойшлогдсон НӨАТ-ын 22,429.5 сая төгрөгийн авлагыг хэрхэн шийдвэрлэсэн.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 36,117.1 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 36,066.9 сая төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 50.2 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 36,117.1 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 2,986.6 сая төгрөгөөс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1. Дотоод албан томилолтын баримтын бүрдэл дутуу, томилолтын хуудасны ирсэн, явсан тэмдэглэл засвартай, гарын үсгээр баталгаажуулаагүйгээр нийт 63.7 сая төгрөгийн томилолтын зардал олгосон, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтын хуудасны баримтын бүрдэл дутуу, ирсэн, явсан тэмдэглэл засвартай, гарын үсгээр баталгаажуулдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.1.2. Тайлант онд ээлжийн амралтын хуваарийг батлаагүй, ажилчдын ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх нөхцөл боломжоор хангаагүйгээр нэр бүхий 785 ажилтныг ээлжийн амралттай байх хугацаанд ажиллуулсан 1,035.4 сая төгрөгийн цалин хөлсийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д "ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр "Журам батлах тухай" 1.2 "Ажил олгогч нь тухайн ажлын жилийн ээлжийн амралтын хуваарийг ажилтны саналыг үндэслэн ажил, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байдлаар зохион байгуулж, жил бүрийн нэгдүгээр улиралд батална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд ээлжийн амралтын хуваарийг батлаагүй, ээлжийн амралттай хугацаанд ажиллуулж цалин хөлсийг олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.1.3. Харилцагч 60 байгууллагын 26,302.6 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөр дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.1.4. Харилцагч 115 байгууллагын 4,237.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 2 харилцагчийн авлагын дүн тооцоо нийлсэн актын дүнгээс 3,678.9 сая төгрөгөөр дутуу буюу зөрүүтэй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.1.5. Бараа материалыг бөөн дүнгээр зарлагадсан, зарлагын баримтыг хүлээн авсан ажилтан, нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажуагүй, баримтын бүрдэл дутуу нийт 166.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.1.3-т "аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын зарлагыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, гарын үсгээр баталгаажуагүй, бөөн дүнгээр зарлагаддаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.1.6. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж 581.6 сая төгрөгийн хөдөлмөр, хамгааллын хувцас хэрэгсэл худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4."Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1."Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10.3."Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 1537 ширхэг 2,772.6 сая төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох үйл ажиллагааг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын

хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх.

5.2.2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Жолоочийн замын хуудас бүрэн хөтлөөгүй, шатахууны зарцуулалтын тайлан гаргаагүй 50.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1-р хавсралтын "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жолоочийн замын хуудсыг бүрэн, үнэн зөв хөтлөх, шатахууны зарцуулалтын тайланг тогтмол гаргаж баталгаажуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Байгууллагын хөрөнгөөр биеийн тамир, спортын тэмцээн зохион байгуулж 59.7 сая төгрөг зарцуулсан	1	59,715.4	-	-	1	59,715.4	-	-	-	-	-	-
2	Дотоод томилолтын баримт дутуу, тэмдэглэл засвартай, баталгаажуулалтгүйгээр 63.7 сая төгрөгийн зардал олгосон.	1	63,681.6	-	-	1	63,681.6	-	-	-	-	-	-
3	Ээлжийн амралтын хуваарь батлаагүй, амралтаар ажиллуулж 785 ажилтанд 1,035.4 сая төгрөгийн цалин олгосон байна.	1	1,035,385.4	-	-	1	1,035,385.4	-	-	-	-	-	-
4	115 харилцагчийн 4,237.9 сая төгрөгийн авлагыг баталгаажуулаагүй, 2 харилцагчийн тооцоо 3,678.9 сая төгрөгийн зөрүүтэй байна.	1	7,916,771.1	-	-	1	7,916,771.1	-	-	-	-	-	-
5	60 харилцагчийн 26,302.6 сая төгрөгийн өр төлбөрийг баталгаажуулаагүй байна.	1	26,302,571.0	-	-	1	26,302,571.0	-	-	-	-	-	-

**“Монголын төмөр зам” Төрийн өмчит хувьцаат компанийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

6	Бараа материалын баримт дутуу, зарцуулалтын тайлгүйгээр 166.9 сая төгрөгөөр зарцуулсан байна.	1	166,887.5	-	-	1	166,887.5	-	-	-	-	-	-
7	Худалдан авалтыг хууль журмын дагуу зохион байгуулаагүй 581.6 сая төгрөгийн хувцас, хэрэгсэл авсан байна.	1	581,590.4	-	-	1	581,590.4	-	-	-	-	-	-
8	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай 150.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна	1	150,000.0	-	-	1	150,000.0	-	-	-	-	-	-
9	Элэгдлээр өртгөө нөхсөн 1,537 хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
10	Жолоочийн замын хуудас дутуу, шатахууны тайлангүйгээр 50.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан.	1	50,239.5	-	-	-	-	1	50,239.5	-	-	-	-
	Дүн	10	36,326,841.9	-	-	8	36,276,602.4	2	50,239.5	-	-	-	-

6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	Засгийн газрын 2025 оны 103 дугаар тогтоолоор түрээсээр ашиглуулахаар шийдвэрлэсэн нийт хөрөнгөөс 328,216.7 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, баримтжуулаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-	
2	Бүтцийн нэгж, албан тушаалын цалингийн сүлжээг батлаагүйгээс цалин хөлсийг хөдөлмөрийн гэрээгээр тогтоож байна.	1	-	-	-	-	-	1	-	
	Дүн	2	-	-	-	1	-	1	-	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 830/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/51/КА-СТА-ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин байгууллагын хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулж 59,715,400.00 (Тавин есөн сая долоон зуун арван таван мянга дөрвөн зуун) төгрөгийн зардал гарсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" 4.2.2-т "хэмнэлтийн горим нь иргэд, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, тэдний дэмжлэгийг хүлээхүйц түвшинд тодорхойлогдсон байх", 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээний зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /О.Батчулуун/, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга /Х.Цогтбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Нэргүй/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ч.МӨНХТУЯА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 831/A0150053

Улаанбаатар хот

САГ - 2026/51/НА - СТА - ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дотоод албан томилолтын баримтын бүрдэл дутуу, томилолтын хуудасны ирсэн, явсан тэмдэглэл засвартай, гарын үсгээр баталгаажуулаагүйгээр нийт 63,681,620.00 (жаран гурван сая зургаан зуун наян нэгэн мянга зургаан зуун хорин) төгрөгийн томилолтын зардал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Томилолтын хуудасны баримтын бүрдэл дутуу, ирсэн, явсан тэмдэглэл засвартай, гарын үсгээр баталгаажуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /О.Батчулуун/, Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга /Х.Цогтбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Нэргүй/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ч.МӨНХТУЯА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 832/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/51/НА-СТА-ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ээлжийн амралтын хуваарийг батлаагүй, ажилчдын ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх нөхцөл боломжоор хангаагүйгээр нэр бүхий 785 ажилтныг ээлжийн амралттай байх хугацаанд ажиллуулан 1,035,385,447.00 (Нэг тэрбум гучин таван сая гурван зуун наян таван мянга дөрвөн зуун дөчин долоон) төгрөгийн цалин хөлсийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д "ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр "Журам батлах тухай" 1.2 "Ажил олгогч нь тухайн ажлын жилийн ээлжийн амралтын хуваарийг ажилтны саналыг үндэслэн ажил, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байдлаар зохион байгуулж, жил бүрийн нэгдүгээр улиралд батална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант онд ээлжийн амралтын хуваарийг батлаагүй, ээлжийн амралттай хугацаанд ажиллуулж цалин хөлсийг олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /О.Батчулуун/, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга /Х.Цогтбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Нэргүй/ нар т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИВАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ч.МӨНХТУЯА

9005109
ATA16087
9025001411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 833/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/51/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харилцагч 115 байгууллагын 4,237,858,207.00 (Дөрвөн тэрбум хоёр зуун гучин долоон сая найман зуун тавин найман мянга хоёр зуун долоон) төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 2 харилцагчийн авлагын дүн тооцоо нийлсэн актын дүнгээс 3,678,912,895.00 (Гурван тэрбум зургаан зуун далан найман сая есөн зуун арван хоёр мянга найман зуун ерэн таван) төгрөгөөр дутуу буюу зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /О.Батчулуун/, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга /Х.Цогтбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Нэргүй/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ч.МӨНХТУЯА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 834/АД150053

Улаанбаатар хот

САГ-2026/51/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харилцагч 60 байгууллагын 26,302,571,036.00 (Хорин зургаан тэрбум гурван зуун хоёр сая таван далан нэгэн сая гучин зургаан) төгрөгийн богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өглөг дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /О.Батчулуун/, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга /Х.Цогтбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Нэргүй/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ч.МӨНХТУЯА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 835/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/51/НА-СТА-ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалыг бөөн дүнгээр зарлагадсан, зарлагын баримтыг хүлээн авсан ажилтан, нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажуулаагүй, баримтын бүрдэл дутуу нийт 166,887,452.00 (нэг зуун жаран зургаан сая найман зуун наян долоон мянга дөрвөн зуун тавин хоёр) төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.1.3-т "аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын зарлагыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, гарын үсгээр баталгаажуулаагүй, бөөн дүнгээр зарлагаддаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /О.Батчулуун/, Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга /Х.Цогтбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Нэргүй/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ч.МӨНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 836/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/51/НА-ЛТА-ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж 581,590,388.00 (таван зуун наян нэгэн сая таван зуун ерэн мянга гурван зуун наян найман) төгрөгийн хөдөлмөр, хамгааллын хувцас хэрэгсэл худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1."Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9."Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /О.Батчулуун/, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга /Х.Цогтбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Нэргүй/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ч.МӨНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 837/АД150053

Улаанбаатар хот

САГ-2026/51/КА - СТА - ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг хийлгэхээр хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулж 150,000,000.00 (Нэг зуун тавин сая) төгрөгийн зардал гаргасан байна.

.Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4 "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл бэлтгэхээр зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /О.Батчулуун/, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга /Х.Цогтбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Нэргүй/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ч.МӨНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 838/А0150053

Улаанбаатар хот

САГ - 2026/51/КА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын төмөр зам ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 103 дугаар тогтоолын дагуу Таван толгой төмөр зам ХХК-аас Монголын төмөр зам ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулахаар нийт 3,364,120,499,399.00 (Гурван их наяд гурван зуун жаран дөрвөн тэрбум нэг зуун хорин сая дөрвөн зуун ерэн есөн мянга гурван зуун ерэн есөн) төгрөгийн суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, үндсэн хөрөнгийг хүлээн авахаас 3,035,903,766,619.00 (Гурван их наяд гучин таван тэрбум есөн зуун гурван сая долоон зуун жаран зургаан мянга зургаан зуун арван есөн) төгрөгийн хөрөнгийг хүлээн авч баримтжуулсан, 328,216,732,780.00 (Гурван зуун хорин найман тэрбум хоёр зуун арван зургаан сая долоон зуун гучин хоёр мянга долоон зуун наян) төгрөгийн хөрөнгийг хүлээн аваагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 8-д "Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй", 31 дүгээр зүйлийн 3-т "Засгийн газар тогтоол, Ерөнхий сайдын захирамжийг тэдгээрийн заалтыг хариуцан гүйцэтгэх байгууллагад тараан хүргүүлж, биелэлтийг нь хянан шалгаж, зохион байгуулан үр дүнг хугацаанд нь тооцож байвал зохино", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.6-д "хуульд заасан бусад тохиолдолд", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Засгийн газрын 2025 оны 103 дугаар "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1-дэх заалт "Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, төмөр замын тээврийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилгоор Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг Монголын төмөр зам ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах арга хэмжээ авахыгтус тус даалгасугай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1."Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8."байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11."хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2025 оны 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаагүй, Таван толгой төмөр зам ХХК-аас 328,216.7 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн аваагүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /О.Батчулуун/, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга /Х.Цогтбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Нэргүй/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ч.МӨНХТУЯА